



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2021/142/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Дорноговь аймаг  
2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон улсын стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДГА	Дорноговь аймаг
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан .....	14
3.1.Ерөнхий зүйл .....	14
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	14
3.4.Материаллаг байдал .....	15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	16
3.7.Шилэн дансны мэдээлэл .....	17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9.Аудитын илрүүлэлт .....	17
Залруулсан алдаа .....	17
Аудитын зөвлөмж .....	17
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4.Менежментийн захидал .....	18
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 1-6/249

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ  
ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Л.ГАНБААТАР ТАНАА

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАН-ӨЛЗИЙ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>28,960,914.50</u></b>	<b><u>44,854,175.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,960,914.50	44,854,175.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	28,960,914.50	44,854,175.00
35410	Бичиг хэргийн материал	5,857,989.00	13,297,747.00
35420	Аж ахуйн материал	22,862,925.50	31,146,428.00
35440	Түлш, шатах тослох материал	240,000.00	410,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>559,045,277.77</u></b>	<b><u>616,006,214.67</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	559,045,277.77	616,006,214.67
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	544,045,277.77	600,547,881.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	520,774,830.00	520,774,830.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,965,166.00	-19,930,332.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,517,151.00	86,517,151.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-61,517,151.00	-62,211,595.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	122,923,774.01	132,299,832.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-112,153,234.07	-87,167,009.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,462,748.60	65,320,383.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,140,800.77	-38,044,494.36
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,812,700.00	1,812,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-227,530.00	-403,660.00
39217	Ном	1,557,956.00	1,580,076.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,000,000.00	15,458,333.33
39301	Програм хангамж	825,000.00	1,325,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-866,666.67
39303	Бусад биет бус хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>588,006,192.27</u></b>	<b><u>660,860,389.67</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>588,006,192.27</u></b>	<b><u>660,860,389.67</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	588,006,192.27	660,860,389.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,647,239.77	164,647,239.77
51101	Өмч: - төрийн	164,647,239.77	164,647,239.77
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-28,773,238.70	44,080,958.70
51210	Өмнөх үеийн үр дүн	-28,773,238.70	-28,773,238.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	72,854,197.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	452,132,191.20	452,132,191.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>588,006,192.27</u></b>	<b><u>660,860,389.67</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>548,379,287.00</b>	<b>692,849,094.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,148,287.00</b>	<b>69,802,894.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,148,287.00	69,802,894.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,126,987.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,126,987.00	40,019,344.00
120009	Бусад орлого	21,300.00	29,783,550.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>546,231,000.00</b>	<b>623,046,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	545,231,000.00	619,546,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	545,231,000.00	619,546,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,000,000.00	3,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,500,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>564,295,597.34</b>	<b>619,994,896.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>564,295,597.34</b>	<b>619,994,896.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	562,035,853.34	608,029,494.60
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	388,632,947.00	431,905,659.00
210101	Үндсэн цалин	290,004,431.00	339,516,159.00
210102	Нэмэгдэл	60,578,091.00	66,016,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,933,000.00	16,041,000.00
210104	Урамшуулал	22,117,425.00	10,331,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,900,506.00	53,977,221.00
210201	Тэтгэврийн даатгал	33,248,944.00	36,704,512.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,862,733.00	4,318,178.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,967,591.00	3,454,540.00
210204	Ажилгүйдлийн даатгал	997,954.00	863,633.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,823,284.00	8,636,358.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,249,700.00	32,635,533.00
210301	Гэрэл, цахилгаан	5,226,211.00	4,257,005.00
210302	Түлш, халаалт	26,588,857.00	26,842,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,434,632.00	1,536,328.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,137,193.00	36,312,312.50
210401	Бичиг хэрэг	10,722,167.00	10,875,482.00
210402	Тээвэр, шатахуун	13,757,200.00	12,475,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,028,350.00	4,616,693.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	384,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,051,276.00	6,856,287.50
210408	Бараа материал акталсны зардал	338,200.00	1,103,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,100,782.00	11,539,250.00
210604	Урсгал засвар	14,100,782.00	11,539,250.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,395,200.00	7,443,600.00

210702	Дотоод албан томилолт	9,395,200.00	7,443,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,851,421.00	8,088,592.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,745,421.00	5,992,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,618,000.00	1,425,292.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	192,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	25,000.00	25,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	25,268,104.34	26,127,327.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,330,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,268,104.34	23,797,327.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,259,744.00	11,965,402.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	2,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,259,744.00	9,465,402.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,259,744.00	9,465,402.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-15,916,310.34</b>	<b>72,854,197.40</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-15,916,310.34</b>	<b>72,854,197.40</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>546,231,000.00</b>	<b>624,564,950.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>546,231,000.00</b>	<b>624,564,950.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	545,231,000.00	621,064,950.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	545,231,000.00	621,064,950.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,000,000.00	5,018,750.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,518,750.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>540,231,000.00</b>	<b>611,084,950.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>540,231,000.00</b>	<b>611,084,950.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>537,971,256.00</b>	<b>599,119,548.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	388,632,948.00	431,905,659.00
210101	Үндсэн цалин	290,004,432.00	339,516,159.00
210102	Нэмэгдэл	60,578,091.00	66,016,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,933,000.00	16,041,000.00
210104	Урамшуулал	22,117,425.00	10,331,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,765,900.00	53,977,221.00
210201	Тэтгэврийн даатгал	33,242,659.00	36,704,512.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,826,453.00	4,318,178.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,943,287.00	3,454,540.00
210204	Ажилгүйдлийн даатгал	991,880.00	863,633.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,761,621.00	8,636,358.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,249,700.00	32,635,533.00
210301	Гэрэл, цахилгаан	5,226,211.00	4,257,005.00
210302	Түлш, халаалт	26,588,857.00	26,821,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,434,632.00	1,557,128.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,441,508.00	38,548,943.00
210401	Бичиг хэрэг	12,146,200.00	10,616,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,127,200.00	12,645,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,090,750.00	5,042,693.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,837,358.00	9,404,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,000,000.00	11,020,000.00
210602	Тавилга	00.00	20,000.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	11,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,395,200.00	7,443,600.00

210702	Дотоод албан томилолт	9,395,200.00	7,443,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,986,000.00	8,088,592.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,880,000.00	5,992,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,618,000.00	1,425,292.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	192,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	25,000.00	25,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	00.00	15,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	15,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,259,744.00</b>	<b>11,965,402.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	2,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,259,744.00	9,465,402.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,259,744.00	9,465,402.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>6,000,000.00</u></b>	<b><u>13,480,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,000,000.00</b>	<b>13,480,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,000,000.00</b>	<b>13,480,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	6,000,000.00	13,480,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,000,000.00	13,480,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-6,000,000.00</u></b>	<b><u>-13,480,000.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	164,647,239.77	452,132,191.20	-12,856,928.36	603,922,502.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,916,310.34	-15,916,310.34
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>164,647,239.77</b>	<b>452,132,191.20</b>	<b>-28,773,238.70</b>	<b>588,006,192.27</b>
D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>164,647,239.77</b>	<b>452,132,191.20</b>	<b>-28,773,238.70</b>	<b>588,006,192.27</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>164,647,239.77</b>	<b>452,132,191.20</b>	<b>-28,773,238.70</b>	<b>588,006,192.27</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	72,854,197.40	72,854,197.40
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>164,647,239.77</b>	<b>452,132,191.20</b>	<b>44,080,958.70</b>	<b>660,860,389.67</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>619,546,200.00</b>	<b>610,080,798.00</b>	<b>9,465,402.00</b>	<b>98.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	619,546,200.00	610,080,798.00	9,465,402.00	98.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	617,046,200.00	607,580,798.00	9,465,402.00	98.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	433,592,900.00	431,905,659.00	1,687,241.00	99.6
210101	Үндсэн цалин	340,685,300.00	339,516,159.00	1,169,141.00	99.7
210102	Нэмэгдэл	66,016,800.00	66,016,800.00	00.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,559,100.00	16,041,000.00	518,100.00	96.9
210104	Урамшуулал	10,331,700.00	10,331,700.00	00.00	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,765,600.00	53,977,221.00	4,788,379.00	91.9
210201	Тэтгэврийн даатгал	41,353,600.00	36,704,512.00	4,649,088.00	88.8
210202	Тэтгэмжийн даатгал	4,353,000.00	4,318,178.00	34,822.00	99.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,482,400.00	3,454,540.00	27,860.00	99.2
210204	Ажилгүйдлийн даатгал	870,600.00	863,633.00	6,967.00	99.2
210205	Эрүүл мэндийн даатгал	8,706,000.00	8,636,358.00	69,642.00	99.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,249,700.00	32,635,533.00	2,614,167.00	92.6
210301	Гэрэл, цахилгаан	5,448,200.00	4,257,005.00	1,191,195.00	78.1
210302	Түлш, халаалт	26,821,400.00	26,821,400.00	00.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,980,100.00	1,557,128.00	1,422,972.00	52.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,201,600.00	37,030,193.00	171,407.00	99.5
210401	Бичиг хэрэг	10,616,200.00	10,616,200.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	11,127,200.00	11,127,200.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,214,100.00	5,042,693.00	171,407.00	96.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000.00	840,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,404,100.00	9,404,100.00	00.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	500,000.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	00.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,000,000.00	21,000,000.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	11,000,000.00	11,000,000.00	00.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,443,600.00	7,443,600.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	7,443,600.00	7,443,600.00	00.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,292,800.00	8,088,592.00	204,208.00	97.5

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,992,300.00	5,992,300.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,618,000.00	1,425,292.00	192,708.00	88.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,500.00	192,000.00	11,500.00	94.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	25,000.00	25,000.00	00.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>15,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,000,000.00	15,000,000.00	00.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2500000.00</b>	<b>2500000.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,500,000.00	00.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>619,546,200.00</b>	<b>610,080,798.00</b>	<b>9,465,402.00</b>	<b>98.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>619,546,200.00</b>	<b>610,080,798.00</b>	<b>9,465,402.00</b>	<b>98.5</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	619,546,200.00	610,080,798.00	9,465,402.00	98.5
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>-</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>5,018,750.00</b>	<b>-5,018,750.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	00.00	5,018,750.00	-5,018,750.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.00	5,018,750.00	-5,018,750.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	1,518,750.00	-1,518,750.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,518,750.00	-1,518,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	3,500,000.00	-3,500,000.00
210602	Тавилга	00.00	3,500,000.00	-3,500,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>00.00</b>	<b>5,018,750.00</b>	<b>-5,018,750.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	5,018,750.00	-5,018,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,500,000.00	-3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,518,750.00	-1,518,750.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Л.Ганбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд байгууллагын данс бүртгэлээс хассан үндсэн хөрөнгийг акталж, устгах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 19-ээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 21 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар цагдаагийн хэсэгтэй болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
- Шүүх хэвийн ажиллах эдийн засаг, хүний нөөц, техник зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 661,440.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,614.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон, гүйцэтгэлийн үе шатанд 6,608.6 мянган төгрөгөөр тооцож, баталгаажууллаа.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Замын-Үүд сум дахь сум дундын Шүүхийн тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72,854.1 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	28,960.9	44,854.1	15,893.2
Үндсэн хөрөнгө	559,045.3	616,006.2	56,960.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>588,006.2</b>	<b>660,860.3</b>	<b>72,854.1</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	588,006.2	660,860.3	72,854.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>588,006.2</b>	<b>660,860.3</b>	<b>72,854.1</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 44,854.1 мянган төгрөг болж 15,893.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2020 оны жилийн эцэст тус газарт Удирдах ажилтны зөвлөгөөн хийхээр товлогдож зөвлөгөөнд зориулж сургалтын материал, бичиг хэргийн материал зэргийг бэлтгэсэн байна. Ковид-19 цар тахалтай холбоотой ариутгал халдваргүйжилтийн хэрэгсэл, маск, комбинзон зэргийг агуулахад бэлэн байлгаж бэлэн байдлын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 616,006.2 мянган төгрөг болж 56,960.9 мянган төгрөгөөр өссөн нь Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон Улсын дээд шүүхээс хөрөнгө авсантай холбоотой байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 16,245.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 64,513.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталж устгасан 34,002.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Болор дуран алдаа шалгах програмаар биет бус хөрөнгө нэмэгдсэн байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 660,860.3 мянган төгрөг болж 72,854.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үр дүнтэй холбоотой байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 144,469.8 мянган төгрөгөөр буюу 26.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 74,315.2 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 55,699.2 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон НДШ-ийн зардлууд байна. Энэ нь Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэлтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 828,036.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 828,036.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 237,475.0 мянган төгрөгөөр бууруулж 590,561.7 мянган төгрөгөөр бөгөөд төсвийн тодотголоор 619,546.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 619,546.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 619,546.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 619,546.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 610,080.8 мянган төгрөгийг зарцуулж 9,465.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 610,080.8 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байна. Энэ нь ажил олгогчоос төлөх НДШ 4,788.4 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 2,614.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3,500.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,518.7 мянган төгрөг, нийт 5,018.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс автомашины засварт 1,518.7 мянган төгрөг, тавилга эд хогшил авахад 3,500.0 мянган төгрөг, нийт 5,018.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн мэдээлэл байхгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 404.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг хэрэгжүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	130.0	1	130.0	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	3	2,420.7	3	2,420.7	-	-	-
Нийт дүн	4	2,550.7	4	2,550.7	-	-	-

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,768.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,768.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд Аж ахуйн материалыг 250.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.
2. Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,518.7 мянган төгрөгийн орлого, зарлагыг дутуу тайлагнасныг залруулав.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа**

###### **1.1 Илрүүлэлт:**

*Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэр төрлийн 17 ширхэг 137.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна.*

###### **1.2 Эрсдэл:**

*Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, дансны үнэ бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү үүсэх.*

###### **1.3 Өгсөн зөвлөмж:**

*Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.*

*Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад  
талархал илэрхийлье.*

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02</b>	Аудитын нэр: <b>Замын-Үүд Сум дундын шүүхийн тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>ДГА-2021/142/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар</b>	мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
0	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг шүүж үзэхэд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэр төрлийн 43 ширхэг 163.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга нягтлан бодогч	Л.Ганбаатар А.Одончимэг
2	Санхүүгийн байдлын тайланд Аж ахуйн материалыг 250.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	250.0	Залруулга	Дарга нягтлан бодогч	Л.Ганбаатар А.Одончимэг
3	Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд 1.5 сая төгрөгийн орлого, зарлагыг дутуу тайлагнасан байна.	1,518.7	Залруулга	Дарга нягтлан бодогч	Л.Ганбаатар А.Одончимэг
<b>ДҮН</b>		<b>1,768.7</b>		-	